



НЭР БҮХИЙ 19 ХУУЛИЙН
КОМПАНИУДАД

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРОО**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26-17-44, Факс: (976-11) 32-90-84,
E-mail: info@frc.mn, http://www.frc.mn

2016.06.30 № 91dd44
танай _____-ны № _____-т

Мэдээлэл ирүүлэх тухай

Танай байгууллагыг Хорооны 2013 оны 451 дүгээр тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдийг бүртгэх тухай журам”-ын дагуу үнэт цаасны зах зээлд оролцогчид оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдээр бүртгэсэн.

Хорооноос тус журмын хэрэгжилтэд хяналт тавих ажиллагаа хийгдэж байгаа тул журмыг хангаж байгаа талаарх дараах нотлох баримтыг 2016 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг мэдэгдэж байна. Үүнд:

1. Орон тооны 2 хуульчдын хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар;
2. Орон тооны 2 хуульчдын Хороо, Хуульчдын холбооноос зохион байгуулсан үнэт цаасны зах зээлийн талаарх төрөлжсөн сургалтад хамрагдсан гэрчилгээний хуулбар;
3. Нийгмийн даатгалын дэвтрийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;
4. Мэргэжлийн хариуцлагын даатгалд хамрагдсаныг нотлох баримт бичгийн хуулбар;
5. Хуульчид нь мэргэжлийн болон ёс зүйн зөрчил гаргаж байгаагүй Хуульчдын холбооны тодорхойлолт.

Тогтоосон хугацаанд нотлох баримтыг бүрэн ирүүлээгүй тохиолдолд тус журмын 4.4.2-т заасан шаардлагыг хангахгүй болсон гэж үзэн Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63.1.6-д “Хороо нь үнэт цаасны зах зээлд аудитын, хөрөнгийн үнэлгээний болон хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдийг бүртгэх, бүртгэлээс хасах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу танай байгууллагыг үнэт цаасны зах зээлд оролцогчид үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийн бүртгэлээс хасах болохыг мэдэгдэж байна.

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА

Б.ОЮУНЦАЦРАЛ



003611